

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 он

Стратеги төлөвлөгөөний бүтэц, агуулга

1. Нийтлэг үндэслэл
2. Мандатын шинжилгээ
3. Алсын хараа
4. Эрхэм зорилго
5. Орчны шинжилгээ
6. Стратегийн зорилго
7. Стратегийн зорилгыг хэмжэх шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги
8. Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал
9. Хавсралт

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2021-2024 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. Нийтлэг үндэслэл:

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/310 дугаар захирамжаар Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, нийслэлийн нутаг дэвсгэрт биеийн тамир, спортыг хөгжүүлэх таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, биеийн тамир, спортын үйл ажиллагааг зохион байгуулж, иргэдэд чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг - Нийслэлийн Спортын хороо болсон бол Монгол Улсын Засгийн 2021 оны 1059 дүгээр тогтоолоор Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг – Биеийн тамир, спортын газар болж нэр өөрчлөгдсөн.

Төрийн албаны тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 36, 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоолууд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар өгөгдсөн заавар, журмын дагуу нийслэлийн хэмжээнд биеийн тамир, спортын талаарх хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулав.

Тус стратеги төлөвлөгөөнд Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Хоёр. Мандатын шинжилгээ

Хүснэгт 1.Мандатын шинжилгээний хүснэгт

Салбарын ажиллагаанд мөрдөгдөж хууль		үйл байгаа	1.Монгол Улсын Үндсэн хууль, 2.Засаг захиргааны, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 3.Төрийн албаны тухай хууль, 4.Хөдөлмөрийн тухай хууль, 5.Төсвийн тухай хууль, 6.МУ-н нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, 7.Биеийн тамир, спортын тухай хууль, 8.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль 9.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 10.Хүүхдийн эрхийн тухай хууль 11.Хүүхэд хамгааллын тухай хууль
Үүнээс	Тухайн салбарын хуулийн тоо		1
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо		10
Ерөнхий чиг үүрэг - 1: Биеийн тамир, спортын салбарыг хөгжүүлэх.			
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид	
ҮЧҮ-1.1. Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах.	Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах;	Биеийн тамир, спортын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг, захиргааны байгууллагын үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах.	
	Нийслэлд биеийн тамир, спортыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлого, хөтөлбөр, стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах.		
	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах.	Биеийн тамир, спортын Улсын хороо, Нийслэл дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод	
Ерөнхий чиг үүрэг -2: Иргэдийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлж, идэвх санаачилгатай ажиллаж буй иргэн, ААН, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх.			

<p>ҮЧҮ-2.1. Харьяа нутаг дэвсгэртээ иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх</p>	<p>Нийслэлийн иргэдийн дунд биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулж оролцоог нэмэгдүүлэх;</p>	<p>Нийслэлийн иргэдийн эрэлт хэрэгцээнд зориулсан биеийн тамир, спортын ажил, үйлчилгээг өргөн хүрээнд, олон нийтийг хамруулан зохион байгуулах.</p> <p>Нийслэлийн иргэн бүрт биеийн тамир, спортын үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах.</p> <p>Биеийн тамир, спортын Улсын хороо, Нийслэл дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод, спортын холбоод, спорт клубууд, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд</p>
	<p>Нийслэлийн хэмжээнд хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорил авах ажлыг зохион байгуулан үнэлж дүгнэн мэдээллийн санд оруулах;</p>	
	<p>Дүүрэг, хороо, хэсэг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж дэх биеийн тамирын хамтлаг, хамтлагийн арга зүйч, иргэдэд биеийн тамир, спортын ажлыг зохион байгуулах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, хамтран ажиллах;</p>	
	<p>Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх;</p>	
<p>Ерөнхий чиг үүрэг 3. Нийслэлд үндэсний болон спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг бэлтгэх.</p>		
<p>ҮЧҮ-3.1. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр спортын холбоод, бусад байгууллагатай хамтран ажиллах.</p>	<p>Нийслэлд үндэсний болон олон улсын хэмжээний спортын арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>Нийслэл Улаанбаатар хотод үндэсний болон олон улсын хэмжээний спортын наадмуудыг зохион байгуулах, спортын төрлүүдийг болон багийн спортыг хөгжүүлэх чиглэлээр спортын холбоодын үйл ажиллагааг дэмжих, тамирчдыг чадавхжуулах,</p> <p>Биеийн тамир, спортын Улсын хороо, Нийслэл дүүргийн Засаг даргын Тамгын газар, Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод, спортын холбоод, спорт клубууд, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд;</p>
	<p>Уралдаан тэмцээний үед хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээ авах.</p>	
	<p>Өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын дунд спортын төрлүүдийг хөгжүүлэх;</p>	
	<p>Багийн спортоор дамжуулан хүүхэд залуучуудын авьяас, ур чадварыг хөгжүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p>	

	Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох дасгалжуулагч тамирчдын амжилтыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;	Тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх өсвөрийн шигшээ баг тамирчдын бэлтгэл сургуулилт хийх нөхцөл боломж, санхүүжилтийг хангах, багш дасгалжуулагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын хороод, Спортын холбоод
ҮЧҮ-3.3.Хүн амын нягтаршил, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, бэхжүүлэх;	Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх. Биеийн тамир, спортын ажил, үйлчилгээ, барилга байгууламж, заал, талбай, хэрэглэл, тоног төхөөрөмжийн чанар, стандарт боловсруулахад оролцох, хэрэгжилтэд нь хяналт тавих;	Стандартыг мөрдөх, судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах, хяналт тавьж, тайлагнах. Биеийн тамир, спортын Улсын хороо, Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Дүүргийн Биеийн тамир, спортын хороод

Гурав. Алсын хараа

Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Алсын хараа - 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Амьдралын чанар ба дундач давхарга” гуравдугаар бүлэг “эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг” гэсэн хэсгийн зорилт 3.5 дахь хэсэг “биеийн тамир, спортын салбарын алсын хараа”-г тодорхойлсон.

Дөрөв. Эрхэм зорилго

Биеийн тамир, спортын үйлчилгээг нийслэл хотын айл өрх, иргэн бүрт хүргэж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж, халааг тасралтгүй бэлтгэх, орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

Тав. Орчны шинжилгээ
Хүснэгт 2.Орчны шинжилгээний дүнг нэгтгэх СВОТ

Дотоод орчин	
Давуу тал	Сул тал
<p>-Бүтэц зохион байгуулалт сайн. -Газрын баримталж байгаа стратеги, зорилго, зорилтууд ойлгомжтой, тодорхой. -Хамт олны уур амьсгал сайн нийтэч, багаар ажилладаг. -Баримт бичгийн бүрдүүлэлт, мөрдөж байгаа дүрэм журам хангалттай. -Процессуудын уялдаа холбоо тодорхой. -Гэрээний харилцаа, үүрэг хариуцлага тодорхой. -Байгууллагаас зохион байгуулагдаж байгаа арга хэмжээний дүрэм, журам, хуульд нийцсэн. -Ажлын гүйцэтгэлийн уялдаа холбоо сайн. -Иргэдийн өргөдөл, санал, гомдлыг авах үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэн. -Өргөдөл, санал, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэж, хариу өгдөг. -Байгууллагын төлөвлөгөөг урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдтэй сайн уялдуулдаг. -Үйл ажиллагааны урсгал, тогтмол зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлдэг. -Спортын ордон, төрөлжсөн спорт цогцолборууд баригдаж байна. -Олон нийттэй харилцах мэдээлэл, технологийн урсгал сайжирсан. -Өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг бэлтгэх тогтолцоог бүрдүүлсэн.</p>	<p>-Уриа байхгүй, хуучирсан -Хүний нөөц дутмаг (өнөөдрийн байдлаар хүний нөөц 70% бүрдүүлэлттэй ажиллаж байгаа.) -Ажилтан, албан хаагчдыг гадаад, дотоодод туршлага судлуулдаггүй, нөхцөл боломжоор хангадаггүй. -Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан тусгай хөтөлбөр, арга хэмжээ байхгүй. -Оффисын бичиг хэргийн зардал дутмаг, хангалттай биш. -Өнгөт принтер байхгүй, одоо байгаа хар цагаан принтер шаардлага хангахгүй. -Олон нийтийн арга хэмжээ явуулах захирамж хугацаа тулгаж гаргадаг тул бэлтгэл ажил хангагдахад хүндрэл учруулдаг. -Ажлын байрны орчин нөхцөл муу (агааржуулалт, зай талбай хангалтгүй) -Ажилтнуудын ашиглаж байгаа ширээ, сандал ажлын байрны өвчлөл үүсгэх өндөр эрсдэлтэй, эргономикийн асуудлыг шийдээгүй. -Ажилтнуудын компьютерын хүчин чадал бага, шаардлага хангахгүй байгаа нь ажлын бүтээмж буурах нөхцөл болж байна. -Дотоод хяналт сайн хийгддэггүй нь үүсэж болох асуудлыг шийдвэрлэхгүй орхих, дараа дахин гарах нөхцөлийг үүсгэх. -Мэргэжлийн албан хаагч байхгүй байгаа нь шаардлагатай судалгаа шинжилгээний ажлыг ихэнх тохиолдолд гадны зөвлөх, судлаачдаар хийлгэх нөхцөл үүсгэдэг. -Иргэн, хуулийн этгээд, төрийн болон төрийн бус байгууллагын зэрэг бүхий л шатанд биеийн тамир, спортын үйл ажиллагаа зохион байгуулахад оролцдог цөөн тооны хүмүүс нь хамрагдаж, массаараа хамрагдах идэвх оролцоо муу. -Улсын төсвөөс баталдаг үйл ажиллагааны урсгал, тогтмол зардлуудын хүрэлцээ хангалтгүй. -Орон нутгийн төсөвт хүн амын эрүүл мэндийг сайжруулахад чиглэгдсэн биеийн тамир, спортын зардал хангалтгүй.</p>
Гадаад орчин	
Боломж:	Эрсдэл:
<p>-Ээлжит сонгуулийн дүнгээс үл шалтгаалан төрийн ажлын залгамж чанар тасралтгүй явагдахаар хуульчилсан. Засгийн газар, Нийслэл, дүүргийн</p>	<p>-Ковид-19 цар тахлын улмаас эдийн засгийн өсөлт зогсонги байдалд орж улмаар буурах хандлагатай байгаа нь биеийн тамир, спортын арга хэмжээний төлөвлөлтөд санхүүжилт буурах эрсдэлтэй байна.</p>

<p>Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл батлагдсан.</p> <p>--Нийслэл болон 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороо (ДБТСХ)-д мэргэшсэн боловсон хүчин, аж ахуйн нэгж, байгууллагуудад биеийн тамирын арга зүйч нар ажиллаж байна.</p> <p>Техник технологийн салбар, хурдтай хөгжиж, дэвшилтэт технологийн шийдэл бүхий программ хангамж, техник хэрэгслийг ашиглах боломж бүрдсэн.</p> <p>-Салбарын мэдээллийн санг бүрдүүлэх ажлын эхлэл тавигдсан.</p> <p>-Улс орны хөгжлийг илэрхийлэх хэмжүүрийн нэг нь биеийн тамир, спортын арга хэмжээ гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрч түүгээр хичээллэх идэвх сонирхол нэмэгдэн амьдралын хэв маягт өөрчлөлт орж, иргэдийн хандлага өөрчлөгдөж байна.</p> <p>-Хүн амын ажиллах, амьдрах орчинд тэдний онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн спортоор хичээллэх орчныг бий болгож байна.</p>	<p>-Иргэд, аж ахуй нэгж, байгууллагын албан хаагчид биеийн тамирын арга хэмжээнд идэвхтэй оролцож эхэлсэн ч тогтмол хэвшил болгох зан үйл дутмаг байна.</p> <p>-Биеийн тамир, спортыг дэмжиж, ивээн тэтгэсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлэх татварын болон бусад хөнгөлөлт үзүүлэх, урамшуулах эрх зүйн орчин бүрдээгүй байгаа нь тэдний идэвх оролцоог бууруулах эрсдэлтэй.</p> <p>- Техник технологийн салбар, хурдтай хөгжиж, дэвшилтэт технологийн шийдэл бүхий программ хангамж, техник хэрэгслийг ашиглах боломж бүрдсэн.</p> <p>-Салбарын мэдээллийн санг бүрдүүлэх ажлын эхлэл тавигдсан.</p> <p>-Салбарын стандартын хэрэгжилт сул.</p> <p>-Бодлого, шийдвэрийн төлөвлөлтөд улс төрийн нөлөөлөл их.</p> <p>-Монгол улсын хүн амын дийлэнх нь Улаанбаатар хотод төвлөрөн амьдарч байна. Жендерийн тэгш байдал алдагдсан.</p>
---	---

Зургаа. Стратегийн зорилго:

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын гадаад, дотоод орчны шинжилгээний үр дүнгээр “тогтворжилтын стратеги”-ийг баримтлах нь оновчтой байна. Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь тогтворжилтын стратегийн хүрээнд сул талаа бууруулж боломжийг нэмэгдүүлэх, давуу талдаа тулгуурлан эрсдэлд өртөхгүй байхаар зорилго, үйл ажиллагаагаа төлөвлөж ажиллана.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын орчны шинжилгээний үр дүнг тус байгууллагын цаашдын хөгжлийн стратегийг тодорхойлох үндэслэл болгов.

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2023-2024 оны стратеги төлөвлөгөөний хүрээнд дараах стратегийн зорилгыг дэвшүүлэв.

Үүнд:

Стратегийн зорилго 1: Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

Стратегийн зорилго 2: Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, эрүүл мэндээ хамгаалах, хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй үйлчилгээг үзүүлнэ.

Стратегийн зорилго 3: Спортын сургалт дасгалжуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж, тамирчдын залгамж халааг бэлтгэж, спортын амжилтыг ахиулна.

Стратегийн зорилго 4: Хүн амын нягтаршил, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлнэ.

Долоо. Стратегийн зорилго, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин:

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын стратегийн зорилго, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг дараах хэсэгт харуулав.

Хүснэгт 3.Стратегийн зорилго, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин

№	Стратегийн зорилго, зорилт	Стратеги	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Шалгуур үзүүлэлтийн утга				Хэрэгжүүлэх нэгж, хэлтэс		Шалгуур үзүүлэлтийн мэдээллийн үзүүлэлтүүд				
					Суурь он	Суурь түвшин	Зорилтот он	Зорилтот түвшин	Үндсэн	Хамтрагч	Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Мэдээллийн бэлэн байдал	Хариуцах нэгж
1	Зорилго-1. Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Бодлогын төлөвлөлт, судалгаа, хяналт, шинжилгээ, үнэлгээний үр дүнг сайжруулах	Салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилт	Хувь	2019	-	2020 2024	100 100	ЗТСХ	СНБТХ	Биелэлт	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр гаргана.	ЗТСХ
	1.Биеийн тамир, спортын байгууллагуудын чадамжийг дээшлүүлэх, хамтын ажиллагаанд	Биеийн тамир спортын салбарын бүтцийг боловсронгуй болгох талаар холбогдогч	Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын хороодын мэргэжилтэн	Тоо (өссөн дүнгээ)	2019	163	2020 2024	207 -	ЗТСХ	СНБХ	Статистик тоон мэдээ	Түүвэр	Жилд 1 удаа	Тухайн онд багтаан мэдээг гаргасан байх	ЗТСХ

	тулгуурласан удирдлагын оновчтой тогтолцоог болгоно.	бий	талуудтай хамтран ажиллах	Биеийн тамирын орон тооны арга зүйчид	Тоо (өссөн дүнгээ)	2019	0	2020 2024	17	СНБТХ	ЗТСХ	Статистик тоон мэдээ	Түүвэр	Жилд 1 удаа	Тухайн онд багтаан мэдээг гаргасан байх	СНБТХ
	2.Биеийн тамир спортын салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж дүгнэлтээр хангана.			Бодлогын төлөвлөлт, судалгаа, хяналт, шинжилгээ, үнэлгээний үр дүнг сайжруулах	Салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилт	Хувь	2019	-	2020 2024	100 100	ЗТСХ	СНБТХ	Биелэлт	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр гаргана.
				Бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2019	-	2020 2024	100 100	ЗТСХ	СНБТХ	Биелэлт	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр гаргана.	ЗТСХ
				ДБТСХ-ын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангасан байх	Тоо	2019	9	2020 2024	9	ЗТСХ	СНБТХ	Үнэлгээ	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр гаргана.	ЗТСХ
				Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан албан хаагчид	Тоо	2019	0	2020 2024	2 2	ЗТСХ	СНБТХ	Тоон мэдээ	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр гаргана	ЗТСХ


2	Зорилго-2. Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, эрүүл мэндээ хамгаалах, хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй үйлчилгээ үзүүлнэ.	Биеийн тамир, спортын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	Бие бялдрын сорилд ABC үнэлгээ авсан иргэд	Хувь (өссөн дүнгээ)	2019	53	2020 2024	57.5 59	СНБТХ	ЗТСХ	Статистик тоон мэдээ	Түүвэр	Жилд 2 удаа	Хагас, бүтэн жилээр гаргасан байна.	СНБТХ
	1.Иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ	Биеийн тамир, спортын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	Биеийн тамирын үйл ажиллагаанд оролцогчид	Тоо (өссөн дүнгээр)	2019	756.451	2020 2024	828,196 864,196	СНБТХ	ЗТСХ	Тайлан	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр тайлагнасан байна.	СНБТХ
			Өвлийн арга хэмжээнд оролцогчид	Тоо (өссөн дүнгээ)	2019	410,000	2020 2024	413.000 414.000	СНБТХ	ЗТСХ	Тайлан	Түүвэр	Жилд 2 удаа	Улирал бүр тайлагнасан байна.	СНБТХ
			Бие бялдрын сорилд ABC үнэлгээ авсан иргэд	Хувь (өссөн дүнгээ)	2019	53 хувь	2020 2024	57.5 59	СНБТХ	ЗТСХ	Статистик тоон мэдээ	Түүвэр	Жилд 2 удаа	Хагас, бүтэн жилээр гаргасан байна.	СНБТХ

			Биеийн тамир, спортын хамтлаг тоо өссөн дүнгээр	Тоо (өссөн дүнгээ)	2019	795	2020 2024	810 815	СНБТХ	ЗТСХ	Тайлан	Түүвэр	Жилд 1 удаа	Тухайн онд багтаан тайлагнах	СНБТХ
			Магадлан итгэмжлэгдсэн спорт клуб	Тоо (өссөн дүнгээ)	2019	11	2020 2024	21 27	СНБТХ	ЗТСХ	Тайлан	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр тайлагнасан байна.	СНБТХ
3	Зорилго-3. Спортын сургалт дасгалжуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж, тамирчдын залгамж халааг бэлтгэж, спортын амжилтыг ахиулна.	Үндэсний болон бусад спортын төрлүүдийг хөгжүүлэх	Спортын тэмцээн уралдаанд хамрагдагчид	Тоо (өссөн дүнгээ)	2019	153,088	2020 2024		СНБТХ	ЗТСХ	Тайлан	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр тайлагнасан байна	СНБТХ
	1.Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын чадварыг дээшлүүлнэ	ур Үндэсний болон бусад спортын төрлүүдийг хөгжүүлэх	Багийн спортын төрлөөр тэмцээн, уралдаанд оролцогчид	Тоо (өссөн дүнгээ)	2019	145,000	2020 2024	145.250 145.300	СНБТХ	ЗТСХ	Тайлан	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр тайлагнасан байна.	СНБТХ
			Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцогч тамирчид	Тоо (өссөн дүнгээ)	2019	7,096	2020 2024	7.210 7.250	СНБТХ	ЗТСХ	Тайлан	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр тайлагнасан байна	СНБТХ

		Зүүн Азийн залуучуудын анхдугаар наадмыг зохион байгуулсан байна.	Хувь	2019	-	2023	100	ЗТСХ	СНБТХ	Биелэлт	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр биелэлт гаргана.	ЗТСХ, СНБТХ
		Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн Спортын төрөл	Тоо (өссөн дүнгээ)	2019	22	2020 2024	24 25	СНБТХ	ЗТСХ	Тоон мэдээ	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр гаргана.	СНБТХ
2.Гадаад харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	Үндэсний болон бусад спортын төрлүүдийг хөгжүүлэх	Гадаад болон дотоодод зохион байгуулсан тэмцээн уралдаан, арга хэмжээ	Тоо	2019	6	2020 2024	6 7	ЗТСХ	СНБТХ	Тоон мэдээ	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр гаргана	ЗТСХ
Зорилго-4. Хүн амын нягтаршил, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлнэ.	Спортын барилга, байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх	1000 хүнд оногдох спортын заалтай барилга байгууламжийн шалны талбайн хэмжээ	м2	2019	60 м2	2020 2024	63м2 64м2	ЗТСХ	СНБТХ	ББ-ын нормд харьцуулалт хийх	Түүвэр	Жилд 1 удаа	Тухайн жилдээ багтаж гаргана.	ЗТСХ

1.Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандартын заал талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Ашиглалтад оруулсан спорт цогцолбор	Тоо	2019	1	2020 2024	Шинээр байгуулсан 6, шинэчилсэн 4	2023 онд шинээр 20 талбай байгуулж, 2 талбай засварлах 2024 онд шинээр 20 талбай байгуулж, 2 талбай засварлах	3ТСХ	СНБТХ	Тайлан	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр гаргана.	3ТСХ
	Шинээр байгуулсан болон засварласан спортын талбай	Тоо	2019		2020 2024			3ТСХ	СНБТХ	Тайлан	Түүвэр	Жилд 4 удаа	Улирал бүр гаргана.	3ТСХ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ –
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Алсын хараа	Идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ.			
	Уриа:			
Эрхэм зорилго	Биеийн тамир, спортын үйлчилгээг нийслэл хотын айл өрх, иргэн бүрд хүргэж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж, халааг тасралтгүй бэлтгэж, орчин нөхцөлийг бүрдүүлнэ.			
	Үнэт зүйл: Мэргэшсэн байх, Манлайлалтай байх, Хууль дээдэх, Ил тод байх, Тэгш шударга байх			
Тэргүүлэх чиглэл	Бодлого, төлөвлөлт, хэрэгжилт	Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх	Үндэсний спорт болон бусад спортыг хөгжүүлэх	Төрийн үйлчилгээг хүргэх
Стратегийн зорилго	Биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, эрүүл мэндээ хамгаалах, хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй үйлчилгээг үзүүлнэ.	Спортын сургалт дасгалжуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж, тамирчдын залгамж халааг бэлтгэж, спортын амжилтыг ахиулна.	Хүн амын нягтаршил, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлнэ.
Стратеги	Биеийн тамир, спортын салбарын бүтцийг боловсронгуй болгож, бодлого төлөвлөлт, судалгаа, хяналт, шинжилгээ, үнэлгээний үр дүнг сайжруулах.	Иргэдэд хүргэх биеийн тамирын спортын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	Үндэсний болон бусад спортын төрлүүдийг хөгжүүлэх	Спортын барилга, байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх
Стратегийн зорилт	1.Биеийн тамир, спортын байгууллагуудын чадамжийг дээшлүүлэх, хамтын ажиллагаанд тулгуурласан удирдлагын оновчтой тогтолцоог бий болгох. 2.Биеийн тамир спортын салбарын бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийг сайжруулахад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж дүгнэлтээр хангах.	1.Иргэдэд хүргэх биеийн тамир, спортын арга хэмжээ, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1.Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлэх, тамирчдын ур чадварыг дээшлүүлнэ. 2.Гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх.	1.Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандартын заал талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, орчин нөхцөлийг сайжруулна.
Хариуцах нэгж	1.Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс 2.Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс	Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс	1.Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс 2.Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс	Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс
Дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороо, хамтлаг, клуб, чийрэгжүүлэлтийн төв, мэргэжилтэн, багш, дасгалжуулагч, арга зүйч нар, иргэд				